

ХИЙ, ШАР, БАДГАНЫ ОНОЛ БА ТЕМПЕРАМЕНТЫН ОНОЛЫН ХАРЬЦУУЛСАН АНАЛИЗ

Д. Цэлмэг
Магистр

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

tselmegke@must.edu.mn

Хураангуй: Уламжлалт анагаах ухааны хий, шар, бадганы онолд тухайн махбод бүрийн онцлог шинж чанар, тэр дундаа хүний овор төрхийн тухай нарийн тодорхойлж өгсөн байдлыг барууны темпераментын онолуудтай харьцуулан дүн шинжилгээ хийж, зарим ижил төстэй талуудыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийсэн. Судалгааны үр дүнд хий махбод нь овор төрхийн хувьд сангвиник, шар махбод нь холерик, бадган махбод нь флегматик болон меланхолик темпераментын шинж чанаруудтай ижил төстэй байгааг тодорхойлж өгсөн.

Түлхүүр үг: Уламжлалт анагаах ухаан, махбод, овор төрх, өвөрчлөл

УДИРТГАЛ

Энэтхэг, Төвд, Монголын уламжлалт анагаах ухаанд бие махбодын нэгдмэл чанартайн зарчимд тулгуурлан “төрөхөөсөө эхлэн бие бялдар, сэтгэл зүйн хувьд ялгаатай (бие бялдар, зан авир, авьяас сонирхол гэх мэт) чалхын өөр өөр чадамж бүхий хувь хүний өвөрмөц онцлогийг танин мэдэх чухал...” гэсэн ба барууны темпераментын онолуудад “хүний зан чанар, зан үйл, сэтгэл зүйд нөлөөлдөг төрөлхийн буюу байгалийн онцлог байна хэмээж, энэ нь хүн бүрийн шинж чанарт нөлөөлж, тухайн хүний зан авир, бодол, шийдвэр гаргах чадварыг тодорхойлно” гэж темпераментын тухай тодорхойлдог. Эндээс харвал хоёр онолд өвөрчлөл (бие бялдарын

өвөрмөц онцлог шинж чанар) ба темперамент гэх ойлголтууд нэг үндэслэлтэй болох нь харагдана. Гэвч темпераментын ангилал, ангилал бүрийн шинж чанарыг ялган тодорхойлсонд ижил төстэй байдал байгаа эсэхийг нарийвчлан судалж, үр дүнг тайлагнасан бүтээл хараахан алга байна. Энэ талын судалгаа хийх, цаашид дорно дахины өвөрчлөлийн онолын агуулгыг их сургуулийн сэтгэл судлалын хөтөлбөрт оруулах хэрэгцээ байна гэж үзэж байна. Ингэснээр сэтгэл судлалын шинжлэх ухаанд Монгол уламжлал, сэтгэхүй өөрийн байр суурийг эзлэн орших боломж бий болох ач холбогдолтой. Энэхүү судалгаанд эртний Энэтхэгийн аюрвед эмнэлгийн ёсонд

хамрагддаг Энэтхэг, Төвд, Монголын уламжлалт анагаах ухааны хий, шар, бадганы онол, мөн барууны зарим темпераментын онолуудыг хамруулж авч үзлээ.

Судалгааны зорилго

Уламжлалт анагаах ухааны хий, шар, бадганы онол ба барууны темпераментын онолуудын темпераментын ангилал, тэдгээрийн ижил төстэй талуудыг харьцуулан судалж тодорхойлох

Зорилт

1. Онолуудад чанарын харьцуулалт хийх
2. Онолуудын ижил төстэй талуудыг тодорхойлох

Онол, арга зүйн үндэс

Онолын харьцуулалт анализ хийх арга

Судалгааны таамаглал

1. Уламжлалт анагаах ухааны хий махбод давамгайлсан өвөрчлөл барууны темпераментын онолын сангвиник хэв шинжтэй давхцана.
2. Уламжлалт анагаах ухааны шар махбод давамгайлсан өвөрчлөл барууны темпераментын онолын холерик хэв шинжтэй давхцана.
3. Уламжлалт анагаах ухааны бадган махбод давамгайлсан өвөрчлөл барууны темпераментын онолын флегматик ба меланхолик хэв шинжтэй давхцана.

Судлах зүйл

- Уламжлалт анагаах ухааны хий, шар, бадган махбод давамгайлсан өвөрчлөл
- Барууны темпераментын онолууд (сангвиник, холерик, флегматик, меланхолик темперамент)

Судалгааны шинэлэг тал

Хий, шар, бадганы онолыг барууны темпераментын онолуудтай харьцуулан судалж буйд энэхүү судалгааны шинэлэг тал оршино.

ОНОЛ, АРГА ЗҮЙ

Эрт дээр үеэс хүний бие бялдрыг физиологийн үйл ажиллагаа, зан байдал, ямар нэг өвчинд өртөх байдалтай нь уялдуулан бүлэглэн ангилах оролдлого хийгдэж ирсэн.

Хий, шар, бадганы онолд бие бялдрын өвөрчлөлийн тухай

Дорно дахины уламжлалт анагаах ухааны нэг өвөрмөц, ялгаатай тал гэвэл хүний бие махбодыг бүхэллэг, нэгдмэл байдалд нь авч үзэж, тэр түвшинд хэрэгждэг зүй тогтлыг үндэслэн өвчнөөс сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх онол аргачлалаа боловсруулсанд оршино. Ингэхдээ тухайн хүний бие махбодын өвөрчлөлийн (өвөрмөц онцлог шинж чанар) онцлогийг харгалзан үзэхийг чухалчилдаг бөгөөд өвөрчлөлийг ялган тогтоох шинж тэмдгийг тодорхойлон өгсөн байдаг [1]. Бие махбодыг бүхэллэг нэгдмэл тогтолцоонд авч үзэж судлахын тулд “бие махбод-тогтолцоо”-г

үүсгэх хүчин зүйлс буюу “анхдагч элемент”-ийг олж тогтоох шаардлага гарч ирдэг. Бүтэц тогтолцооны арга зүйг ашиглан хийсэн судалгааны үр дүнгээс харвал хий, шар, бадган нь Буддизмын гүн ухаанд алимад юмс үзэгдлийн түгээмэл эхлэл гэж үздэг язгуурын их таван махбодоос (шороо, ус, гал, хий, огторгуй) хийсвэрлэн гарсан байна. Тэдгээр нь амьд бие махбодын бүхий л хэсэгт оршин хадгалагддаг, үйл ажиллагааг нь зохицуулан хянах үүрэгтэй, зөвхөн өөрсдийн бэлэг чанараараа тодорхойлогддог “бие махбод-тогтолцоо”-г үүсгэх хүчин зүйл болж, тэдгээрийн анхдагч түгээмэл чанар нь анхдагч элементийг илэрхийлж чадахуйц ухагдахуун юм [2]. Иймээс хий, шар, бадган нь

- Өвчний шалтгаан болдог,
- Бие махбодын өвөрмөц чанарыг нөхцөлдүүлдэг,
- Халуун, сэрүүн, хүнд, мохдог, хөнгөн, тослог гэх мэтээр зөвхөн өөрсдийн бэлэг чанарууддаа тодорхойлогддог байна.

Энэтхэг, Төвд, Монголын уламжлалт анагаах ухаанд (Дорнын уламжлалт анагаах ухаан нь Хятадын ба Энэтхэгийн гэсэн хоёр том урсгалд ангилагддаг. Энэтхэгийн аюурведийн ухаанд Энэтхэг, Төвд, Монголын уламжлалт анагаах ухаан багтана) хий, шар, бадганы сургаалд үндэслэн хүний бие бялдрын өвөрчлөлийг 7 үндсэн төрөл байж

болохыг заасан. Хий, шар, бадганыг бие махбодыг зохицуулагч эхлэл гэж үзээд хий, шар, бадганы дан дангаараа давамгайлсан 3, хосолсон 3 (хий-шар, хий-бадган, шар-бадган), хурмал 1 (хий-шар-бадган), бүгд нийлээд 7 төрөл байна гэж үзнэ. Ийнхүү өвчний шалтгаан гэх хий, шар, бадган нь бие махбодыг чанараар нь ялган өвөрчлөл болон зан авирын онцлогийг тодорхойлж өгдөг байна [1]. Шинжлэх ухааны доктор Б.Дагвацэрэн нарын 2021 онд хийсэн өвөрчлөл тогтоох судалгааны үр дүнгээс харахад дан ба хурмал хэлбэрийн өвөрчлөлтэй хүмүүс маш ховор ба бараг илрээгүй байв. Харин хий-шар давамгайлсан өвөрчлөлтэй хүн 57%, шар-бадган давамгайлж хавсарсан өвөрчлөлтэй хүмүүс 24%, бадган-хий давамгайлж хавсарсан өвөрчлөлтэй хүмүүс 19% тус тус байсан [1].

Бие бялдрын онцлогийн хувьд, хий давамгайлсан өвөрчлөлтэй бол туранхай, хөнгөн жинтэй, арьс хуурай, хүйтэн, ширүүн, нүд жижиг, дальдачсан, хуурай харагддаг, шар давамгайлсан бол бие болон жин дунд зэрэг, арьс зөөлөн, тослог, бүлээн, нүд дунд зэрэг хэмжээтэй, нэвт цоргисон харцтай, ногоон шардуу өнгөтэй, харин бадган давамгайлсан өвөрчлөлтэй хүмүүсийн хувьд бие тарган, хүнд жинтэй, арьс өөхлөг, тослог, хүйтэн, цайвар өнгөтэй, нүд нь том, дур булаам, хар хүрэн өнгөтэй,

өтгөн сормуустай байхыг тодорхойлжээ.

Хий, шар, бадганы онолд бие бялдрын онцлогоос гадна хоолны дуршил, биеийн идэвх, оюуны идэвх, авир төрх, ой ухаан, нойрсолт, ярианы онцлог, хөрөнгө мөнгөнд хандах хандлага, тухгүй байх орчин нөхцөл, шүтлэг, биеийн хаана эвгүйрхдэг зэргийг нарийн тодорхойлж өгсөн нь энэхүү хувь

хүний өвөрчлөл хэмээх ойлголт хүний сэтгэл зүйн шинж чанарын тухай, цаашлаад сэтгэл судлалын ухааныг агуулсан болохыг харуулна. Хий, шар, бадган давамгайлсан өвөрчлөл тус бүрийн онцлогийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 1. Хий, шар, бадган давамгайлсан өвөрчлөлийн онцлог шинж чанарууд

Онцлог шинж чанар	ХИЙ	ШАР	БАДГАН
Хоолны дуршил	Тогтмол биш	Тогтмол сайн	Удаан өлсдөг
Ялгадас	Хатсан, хатуу	Зөөлөн, тослог	Өтгөн, тослог
Биеийн идэвх	Хөдөлгөөн их	Дунд зэрэг	Унтамхай
Оюуны идэвх	Санаж сэдсэн, идэвхитэй	Түрэмгий, ухаалаг	Амгалан, удаан
Авир төрх	Хувирамтгай, сэтгэл санаа түгшсэн	Өөртөө итгэлтэй, бардам, атаач, сөргөлдөмтгий	Тайван, хүлцэнгүй, илэн далангүй, олон саналгүй
Ой ухаан	Ойрын юмыг санахдаа сайн, ялихгүй зүйлийг мартаж нь амархан	Хурц	Удаан боловч мартажгүй
Нойр	Өнгөц, сэрэмтгий	Чимээнээс сэрэх	Гүн бөх, удаан
Яриа	Түргэн	Хурц, ширүүн	Удаан, нэг өнгөөр
Хөрөнгө мөнгө	Аар саар юманд үрэлгэн	Тансаглаж үрдэг	Хямгатай, хоолонд үрдэг
Тухгүй орчин	Салхи жавар, өндөр газар	Халуун хуурай, нам дор газар	Нойтон, чийгтэй орчин
Шүтлэг	Тогтворгүй	Шүтдэггүй, нэг шүтвэл улайрна	Сүжиг бишрэлтэй
Бие эвгүйрхдэг хэсэг	Хүйснээс доош, хөл хүртэл	Хүйснээс зүрхний хооронд	Зүрхнээс доош хэсэгт

Эх сурвалж: Дагвацэрэн Б., Батчимэг Ө. Өвчнөөс урьдчилан сэргийлэх уламжлалт анагаах ухааны ёс, 2022. Х36.

Үүнээс гадна уламжлалт анагаах ухааны үндсэн судар бичиг гэгдэх “Анагаах ухааны дөрвөн үндэс” номд айлтгасныг иш үндэс болговол, хий давамгайлсан өвөрчлөлтэй хүний бие туранхайдуу, бөгтөр, намхан, арьс салстын өнгө нь бараавтар буюу хөхөлбөр, амархан даардаг, нойронд сэргэг, их ярих, дуулж бүжиглэх,

тоглож наадах, ноцолдох, мөрийцөх дуртай. Мөн амтлаг, исгэлэн, гашуун, халуун амттанд илүү дуртай. Хэрэв биеийн ерөнхий байдал нь дунд зэрэг мариатай, арьс салст, үсний өнгө шар буюу шаравтар туятай, амархан өлсөж цангадаг, өлссөн үедээ уур уцаартай болдог, омог, шар ихтэй, хөлс үнэр их, амтлаг, гашуун, эхүүн

амтанд дуртай зэрэг өвөрмөц онцлогтой бол шар давамгайлсан бие бялдрын өвөрчлөлд хамаарна. Харин бадганы бие бялдрын өвөрчлөл давамгайлсан хүний хувьд арьс салстын өнгө цайвар, ноомой, дөлгөөн, тайван аядуу зантай, өлсөж ундаасахад тэсвэртэй, нойр ихтэй, халуун, исгэлэн, эхүүн амтанд дуртай байх жишээтэй юм [1; 3].

Түүнчлэн, доктор М.Амбага ба Б.Саранцэцэг нарын “Хий, шар, бадган-мембрант байгууламж” бүтээлд хий давамгайлсан өвөрчлөлтэй хүний овор төрхийг бие бялдар бага сага, хатангир, нойр бага, биеийн илч өчүүхэн гэж, шар давамгайлсан хүний хувьд бие бялдар дунд зэрэг, биеийн илч их, өлсч ундаасахдаа хялбар, оюун ухаан хурц, сэргэлэн гэж, харин бадган давамгайлсан хүнийг бие бялдар халхгар том, бие хүйтэн, нойр илүү, ой сайтай, уужуу талбиу сэтгэлтэй гэж тус тус тодорхойлжээ [4].

Энэтхэг, Төвд, Монголын уламжлалт анагаах ухааны хий, шар, бадганы онолд эрдэмтэн судлаачдын бичсэн хэд хэдэн эх сурвалжаас харахад “хий давамгайлсан өвөрчлөл” гэх ойлголт нь сангвиник темпераментын онцлог шинж чанаруудтай ижил төстэй шинж чанарыг агуулсан, “шар давамгайлсан өвөрчлөл” нь холерик темпераментын онцлог шинж чанаруудтай ижил төстэй олон шинжийг агуулсан, харин “бадган

давамгайлсан өвөрчлөл” бол флегматик ба меланхолик темпераментуудын шинж чанаруудыг агуулсан болохыг олж харж болж байна.

Барууны темпераментын онолуудад бие хүний төрөлхийн шинж чанарын тухай

Темперамент гэх ойлголтод сэтгэцийн үйл ажиллагааны хөдөлгөөнтэй тодорхойлолтуудыг авч үзнэ. Темперамент ерөнхий идэвхт шинж, хөдөлгөөний онцлог шинж, сэтгэл хөдлөлийн шинж зэрэг үндсэн гурван хүрээнд яригдана. Темперамент төрөлхийн, биологийн хүчин зүйлээр тодорхойлогддог.

МЭӨ 460-377 онд Гиппократ хүний бие бялдрын хэд хэдэн төрлийг биед агуулагдах үндсэн шингэн бодисуудын харьцаагаар ангилан тодорхойлж байсан нь барууны темпераментын онолуудын анхдагч гэгддэг. Гиппократын онолд сангвиник буюу цус ихтэй, холерик буюу цөс ихтэй, флегматик буюу салс ихтэй, меланхолик буюу хар цөс ихтэй гэсэн 4 төлөвийг тодорхойлсон байдаг. Дэлгэрүүлж авч үзвэл,

- Сангвиник (агаар бэлгэ тэмдэг): дулаан, чийглэг, хурдан, сул,
- Холерик (гал бэлгэ тэмдэг): дүрсхийсэн, халуун, хурдан, хуурай,
- Флегматик (ус бэлгэ тэмдэг): хүйтэн, чийглэг, удаан, сул,

- Меланхолик (газар бэлгэ тэмдэг): хүйтэн, хуурай, удаан, хүчтэй зэрэг шинж тэмдгээр тодорхойлсон байдаг [5].

Темперамент тус бүр нь өөрийн онцлог шинжтэй бөгөөд сангвиник нь идэвхтэй, эрч хүчтэй, хөдөлгөөнтэй, асуудлыг шийдвэрлэх чадвартай, аливаа ажлыг хийж гүйцэтгэх арга эвийг амархан олдог, элдэв асуудлаас эвтэйхэн мултардаг, сонирхолгүй зүйлээ үр дүн гаргахгүй хаях талтай, нийтэч, хэл ярианы хөгжил сайн, олны дунд амархан байр сууриа олдог, удирдан манлайлах чадвартай, сэтгэлийн хөдөлгөөнтэй, найзархаг харилцаатай байна. Холерик темпераменттай хүн нь цочмог, шаралхуу, дүрсхийсэн ууртай, хариу үйлдэл хурдан, баярлах, гомдох нь хурдан, хамт олны дотор манлайлах чадвартай, өөрийн хүч чадалд итгэлтэй, өөрийнхөөрөө асуудлыг шийдэх хандлагатай, шинийг санаачлах, асуудлыг шийдвэрлэхдээ гарамгай, сонирхол нь амархан өөрчлөгддөг байх талтай. Флегматикууд бол тайван, дөлгөөн, буурь суурьтай, хариуцлагатай, үүрэг даалгаврыг цаг тухайд нь гүйцэтгэдэг, хамт олныг аялдан дагалдах, бусдаас ялгарахгүй байхыг илүүд үздэг, хэл ярианы чадвар сайн боловч тэр болгон түрүүлж дуугарахгүй, бодож эргэцүүлдэг, сонирхолтой ч сонирхолгүй ч ажлыг хийж дуусгадаг, баримттай үр дүнг л гаргаж тавьдаг зан чанартай байна.

Эцэст нь меланхолик хэв шинжийн хүмүүсийг ноомой, дөлгөөн, идэвхгүй, дуу сул, бүрэг ичимхий, удаан, үүрэг даалгаврыг гүйцэтгэхдээ удаан боловч үр дүнтэй, эмзэг, уян зөөлөн, үнэнч, аль болох хүний нүдэнд өртөхгүйг хичээдэг, хэл ярианы хөгжил сул, хүнтэй эвээ олж ярих чадвар тааруу, удаан боловч аливаа асуудлын эцсийн үр дүнг заавал харахыг хичээдэг зан чанартай гэх мэтээр тодорхойлжээ.

Дараа дараагийн онолууд Гиппократын онолд суурилсан байх нь олон. Тухайлбал, II зуунд тэмдэглэгдэн үлдсэн Галений дөрвөн үндсэн темпераментын онол темперамент тус бүрийн сэтгэл зүйн дүр зургийг нарийн гаргаж ирсэн байдаг [6].

Судлаачид темпераментын физиологи үндсийн талаар олон санаа дэвшүүлж байсан бөгөөд хүний бие дэх цусны химийн бүтэц, цусны судасны өргөн ба зузаан, бодисын солилцооны онцлог, дотоод шүүрэл ба дааврын үйл ажиллагаа, мэдрэлийн болон булчингийн эдийн хэмнэл, мэдрэлийн тогтолцооны шинж зэргийг түүнтэй холбон авч үзэж байв. Үүний дотроос хамгийн их газар авсан нь И.П.Павловын темпераментын үндсийг мэдрэлийн тогтолцооны хэв шинжээр тайлбарласан онол юм. Тэрээр хүний мэдрэлийн тогтолцооны үндсэн шинжийг тодруулан хүч, харьцаа, хөдөлгөөнөөр дамжуулан тодорхойлжээ [5]. Өөрөөр хэлбэл, мэдрэлийн тогтолцооны хөөрөл

саатлын процессын хүчтэй ба сул, тэнцвэртэй ба тэнцвэртэй бус, хөдөлгөөнтэй ба удаан хэв шинжүүдээр темпераментын хэв шинжүүдийг тодорхойлсон. Хэрэв мэдрэлийн тогтолцоо хүчтэй, тэнцвэртэй бус, хөдөлгөөнтэй бол холерик темпераменттай, хүчтэй, тэнцвэртэй, хөдөлгөөнтэй байвал сангвиник, хүчтэй, тэнцвэртэй хэрнээ удаан бол флегматик, харин мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагаа сул бол меланхолик темпераменттай байна гэсэн [7; 8].

Мөн бие бялдрын онцлог, биеийн галбир төрхөөр темперамент тодорхойлох оролдлого хийсэн олон онол байгаагаас дурьдвал К.Сиго (1914), Э.Кречмер (1921), В.В.Бунака (1937), У.Шелдон (1940) зэрэг байна [9]. Тухайлан дэлгэрүүлбэл, У.Шелдон хүний биеийн бүтэц (соматотип) болон зан төлөв, темпераментынхоорондын хамаарлыг судалж, хүний биеийн хэлбэр галбирыг 3 үндсэн хэв шинжид ангилан тус бүрийн зан чанаруудыг тодорхойлсон. Тэдгээр нь, эндоморф буюу бөөрөнхий биетэй, өөх тос ихтэй, сул булчин, удаан бойжих талтай хэв шинж, мезоморф буюу хүчирхэг булчинтай, атлетик биетэй хэв шинж, эктоморф буюу туранхай, сул булчинтай, өндөр, эмзэг биетэй хэв шинжүүд юм. Харин зан төлөвийн хувьд эндоморф нь найрсаг, тайван, дотно харилцаатай, идэвхгүй, амралтад дуртай (флегматик), мезоморф нь

идэвхтэй, тэсвэртэй, дайчин, шийдэмгий, мэдрэмж багатай (холерик), харин эктоморф бол удаан сэтгэдэг, мэдрэмтгий, нуугдмал, стрессд өртөмтгий зан чанартай (меланхолик) гэж тодорхойлсон нь мөн л анхдагч Гиппократын онолын темпераментын ангилалтай зарим талаараа давхцаж харагддаг [10].

Сэтгэл судлалд хамгийн их түгсэн барууны темпераментын ихэнх онолуудад темпераментыг сангвиник, холерик, флегматик, меланхолик гэсэн дөрвөн хэв шинжид ангилан авч үзэх нь ижил төстэй байгаа бөгөөд темпераментуудын шинж чанаруудыг тодорхойлсон нь мөн ижил төстэй байна.

СУДАЛГАА

Уламжлалт анагаах ухааны хий, шар, бадганы онол ба барууны темперамент, зан төлөвийн онолуудад харьцуулсан чанарын анализ хийж, үр дүнг бичиглэсэн болно.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Онолын харьцуулалт анализын үр дүнд “Уламжлалт анагаах ухааны хий махбод барууны темпераментын онолын сангвиник хэв шинжтэй давхцана” гэсэн 1-ээр таамаглал, “Уламжлалт анагаах ухааны шар махбод барууны темпераментын онолын холерик хэв шинжтэй давхцана” гэсэн 2-аар таамаглал, “Уламжлалт анагаах ухааны бадган махбод

барууны темпераментын онолын флегматик ба меланхолик хэв шинжтэй давхцана” гэсэн 3-аар таамаглал батлагдлаа. Хүний бие, сэтгэцийн эрүүл мэндийг "сэтгэл-бие-нийгэм"-ийн нэгдмэл байдалд авч үзэх хандлага газар авч буй энэ цаг үед хоёр онолын нэгдэл давхцал судалгааны ач холбогдолтой юм.

Цаашид эдгээр онолуудын өргөтгөсөн талбарууд, тухайлбал улирал болон газарзүйн байрлалаас шалтгаалан бие махбодын өвөрчлөлд орох өөрчлөлтүүд, өвөрчлөлийн насжилтаас шалтгаалах байдал зэргийн тухай үзэл баримтлалуудыг харьцуулан судлах хэрэгцээ урган гарч ирж байна.

Түүнчлэн уламжлалт анагаах ухааны 7 өвөрчлөл тус бүрийн сэтгэл зүйн онцлогийг орчин үеийн сэтгэл зүйн тестээр судлан тогтоож, тоон судалгааны үр дүнг харьцуулах, хамаарлыг тогтоох дараа дараагийн судалгааны зорилго тавигдаж байна.

Мөн уламжлалт анагаах ухааны хий, шар, бадганы онолын өвөрчлөлийн тухай агуулгыг их сургуулийн сэтгэл судлалын хөтөлбөрт оруулан оюутнуудын хүртээл болгох нь ач холбогдолтой гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Уламжлалт анагаах ухааны хий махбод давамгайлсан өвөрчлөлийн шинж чанарууд барууны темпераментын онолын сангвиник хэв шинжтэй ижил

төстэй байна. Харин шар махбод давамгайлсан өвөрчлөлийн шинж чанарууд холерик темпераментын хэв шинжтэй давхцаж байна. Мөн бадган махбод давамгайлсан өвөрчлөлийн шинж чанарууд нь флегматик ба меланхолик темпераментын зан чанаруудтай олон талаараа ижил төстэй байна.

Эндээс МЭӨ 3000-1500 оны хооронд үүссэн гэгддэг Энэтхэг, Төвд, Монголын уламжлалт анагаах ухааны хий, шар, бадганы онолд хүний сэтгэц, зан үйлийн үндсэн шинжүүдийг бие бялдрын онцлогтой холбон тодорхойлсон бөгөөд тэр нь барууны темпераментын онолуудтай ижил төстэй байгааг тодруулав. Өөрөөр хэлбэл, Гиппократын темпераментын онол (МЭӨ 300 он орчим) анхдагч темпераментын онол биш, мөн темпераментын тухай анхны үзэл баримтлал Дорнын уламжлалт анагаах ухаанаас гаралтай гэж үзлээ.

НОМ ЗҮЙ

1. Дагвацэрэн Б., Батчимэг Ө. Өвчнөөс урьдчилан сэргийлэх уламжлалт анагаах ухааны ёс. Улаанбаатар: «АДМОН ПРИНТ», 2022. х
2. Дагвацэрэн Б. Монгол—Төвд анагаах ухааны онол арга зүйн үндэс. Улаанбаатар: «Питер», 1996. Х
3. Анагаах ухааны дөрвөн үндэс. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1991. х
4. Амбага М., Саранцэцэг Б. Хий, шар, бадган-Мембрант байгууламж. Улаанбаатар: «Адмон ХХК», 2013. х

5. Батсайхан Б., Дэлгэржав М. Ерөнхий сэтгэл судлал. Улаанбаатар: «Соёмбо принтинг», 2013. х
6. <https://en.lapsicologiadetodo.com/post/galen-s-theory-of-the-four-basic-temperaments>
7. https://en.wikipedia.org/wiki/Pavlov's_typology
8. <https://www.slideserve.com/celina/physiological-bases-of-behavior>
9. <https://allasamsonova.ru/typy-teloslozhenija-somatotipy/>
10. <https://www.simplypsychology.org/sheldon-constitutional-theory-somatotyping.html>